

## ЖОЧИ ЧИНГИСИЙН ТӨРСӨН ҮР МӨН

А.Цанжид<sup>1</sup>

Есүй хатан дөрвөн хүүгийнхээ чухам хэнийг залгамжлагчаа болгох вэ хэмээн асуухад, Чингис хаан ухаант хатнаа магтаад “Хөвүүдийн минь ах Жочи буй зэ, юу хэмээмүй, чи? Хэл” хэмээв. Жочийг дуугарахын өмнө Цагаадай өгүүлрүүн: “Жочийг хэл хэмээхдээ, Жочид юу түшин өгүүлмүй. Энэ мэргидийн чул олзуурт хэр мэдүүлэх бид? хэмээхүй лүгээ Жочи босоод, Цагаадайн заханд тусч өгүүлрүүн: “Хан эцэгт бус эс хэмээгдлээ. Чи намайг хэр ялгамуй?...”<sup>2</sup> хэмээв. Нээрээ л хан эцэг нь Жочийг миний хүү биш гэж хэлсэнгүй. Цагаадай хаанаас, юунаас мэдсэн юм бол? Эсвал Цагаадайн хэлсэн “чул олзуур” гэдэг энэ хоёр үгийг өнөө цагийнхан ташимгай ухав уу? Ц. Дамдинсүрэн гуай энэ хоёр үгийг “орхидос” хэмээн орчуулж, яг түүний ард хаалтан дотор “Бөртэ хатан, мэргэдэд олзлогдож байгаад жирэмсэн болж ирсэн учраас ингэж хэлсэнд”<sup>3</sup> гэсэн тайлбар хийсэн буй. Ийнхүү дурдсанаас болсон уу, Жочи бол Чингисийн өөрийн нь хүүхэд биш, мэргидийнх гэдэг үзэл дэлгэрч, Жочи өөр хүний хүүхэд учраас нэр нь “зочин” гэсэн үгнээс гаралтай хэмээн хэлэлцэх нь ч байсаар ирэв. Сүүлийн үед бүтээх туурвих эрх чөлөө олдсоны завшааныг дураар ашиглагч заримууд Жочийг Чингисийн хүүхэд биш гэх нь байтугай, Чингис ч бас Есүхэйн хүү мөн бишид эргэлзсэн маягийн утгатай уран бүтээл хийх болов. Бүтээх туурвих эрх чөлөөг хүндэтгэхийн зэрэгцээ, монгол хүмүүн бидний хувьд улсын эцэг болсон аугаа их түүхэн хүний тухай элдэв таавар үг ярих нь өөрийн эцэг эх, гарал үүслийг гутаасантай агаар нэгэн биз ээ. Сайн хүний нэрийг гурав худалдаж иддэг гэдэгчлэн Их Чингис хааны нэрийг барин “хоол олж идэгсэд” олширсны зарим нь сайшаан магтаж, зарим нь муулж, зарим нь хийж буй хоол хүнс, бараа таваараа хүртэл эзэн богдын нэрээр нэрлэж, аяглахгүй ааш алга. Түүн дээр бас нэг төрлийн ийм хүмүүс гарч ирсэн нь Чингис хааны намтрыг элдвээр мушгин гуйвуулж, манайхны одоо их хэрэглэдэг гадаад үгээр ярих юм бол “сенсаац” хийх (шуугиан тарих) болжээ.

Энэ бүхнийг эрэгцүүлэн бачимдахын эрхэнд миний бие “Нууц товчоо”-г дахин дахин уншиж, үг өгүүлбэр бүрийг шүүрдэн үзсэн юм. Түүний эцэст “орхидос” гэдэгтэй санал нийлж болмооргүй санагдсан билээ. Тэгээд уг саналаа бусдад танилцуулж мэргэн оюунаар нь тунгаалгая хэмээн бодлоо. Гэвч би эх оронч, үндэсний үзэлтэй хүн болох гэж үнэнийг гуйвуулах гээгүй гэдгээ юуны түрүүнд хэлье.. Цагаан дээрх харыг л хэрхэн ухаарснаа уншигч танаа толилуулж буй хэрэг.

<sup>1</sup> Доктор, профессор.

<sup>2</sup> "Монголын Нууц Товчоон", Шинээр хөрвүүлэн буулгаж, тайлбар хийсэн Ш.Чоймаа, Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал I боть, УБ, 2006, 202-р тал.

<sup>3</sup> "mongyul-un niyuča tobčiyān", čendü-yi damdinsürüing orčiyulba, 1947 on, ulayan bayatur qota, 250 tal-a.

Дээр дурдсан яриаг эргэн санавал, Жочи хэний хүү болохыг Хаан эцэг, хатан ээжээс илүү мэдэх хүн хэн байх вэ. Тэмүжин мэргидэд Бөртэ-гээ алдаад Тоорил ханд ирж хэлсэн нь: “Гурван Мэргид гэнэн бүхүйд ирж, эм **хөвүүгээ** (зохиогчийн тодруулга) дагуулиж автав. Хан эцэг минь! Эм **хөвүүг** аварч өгтүгэй хэмээн ирэв, бид”<sup>4</sup>. Энд ямар **хөвүүгийн** тухай ярьсан хэрэг вэ? Тэмүжинтэй цуг Тоорил ханыд Хасар, Бэлгүтэй хоёр очсон бөгөөд хоёр дүү нь хараахан гэр бүлтэй болоогүй цаг байв. Тэгээд ч “Нууц товчоо”-нд Мэргидүүд Бөртэ, Бэлгүтэйн эх хоёрыг л олзлоод “Өгээлүний өс аван, эдүгээ **эмсийг ану** (зохиогчийн тодруулга) авав. Өшөөгөөн авав”<sup>5</sup> гээд бусдын нь араас хөөхөө больж буцсан тухай өгүүлсэн байдаг. Хөвүү гэдэг үг “Нууц товчоо”-г хөрвүүлэгчдийн алдаагаар буй болов гэвэл тийм биш аж. Ц. Дамдинсүрэн, Д. Цэрэнсодном, Ш. Чоймаа нарын аль алиний нь хөрвүүлэгт “хөвүү” гэдэг үг байна. Түүнчлэн Б. Сумьяабаатарын нөр их хөдөлмөрөөр бүтсэн “Нууц товчоо”-ны үсгийн галигт “хөвү бэн” хэмээжээ<sup>6</sup>. Энд яах аргагүй эм, **хөвүүг** аврах тухай ярьсан ажээ. Мөн И.Рахевилцийн “МНТ”-ны латин галиг эхэд «... qurban merkit-te genen büküü-tür irejü eme kö'ü-ben dauliju a[b]daba qan esige minu eme kö'ü aburaju öktügei ke'en ireba...»<sup>7</sup> гэж буй. Чухам ямар хөвүүний тухай ярьсан бэ гэдгийг “Нууц товчоо”-той ойролцоо цаг үед зохиогдсон, зохиогчдын нь өгүүлснээр өмнөх үеийн ном зохиол, мэдэх хүмүүсийн яриаг ашиглаж бүтээсэн Жувэйний “Дэлхийг байлдан дагуулагчийн түүх”, Рашид Ад-Диний “Судрын чуулган” хоёрыг сөхөн хайваас, Рашид Ад Дин чухал мэдээ үлдээжээ. “Түүний ууган хөвүүн нь Жочи бөгөөд Дешт-и Химчакийн (Кипчакийн) бүх эзэнтэн, хан хөвүүн нь түүний удмынхнаас гаралтай билээ. Энд чухам дараах зүйлийг ярьцгаадаг юм. Үүнд Чингис Мэргид аймгийнхантай байлдаж давамгайлж байхад, Бүртэ Үжиний хөл нь хүндэрсэн байлаа. Гэтэл мэргэдүүд түүнийг олзлон аваачсан байна. Тэр үед мэргэдүүд Ван ханы хооронд тайван харьцаатай байсан болохоор Мэргидүүд түүнийг, Ван ханд хүргэлээ. Ван хан Чингис хааны эцэгтэй сайн нөхөд байсан учир Чингис хааныг хөвүүн гэдэг, мөн Бүртэ үжинийг бэрээ гэж үздэг байсан болохоороо түүнийг хайрлан хүндэтгэлтэй байлгаж байлаа... Чингис хаан энэ тухай мэдмэгцээ эхнэрээ авч ирүүлэхээр Ван хан руу Жалайр овгийн Сартан ноёны эцэг Сабаг явуулжээ... Тэгээд Бүртэ үжин Чингист очихоор явж байтал замд нь Жочи ертөнцөд мэндэлжээ... Жочи гэж нэрлэсэн учир уул хөвүүн жочирхон мэндэлсэн болохоор ийн нэрлэжээ”<sup>8</sup>. Рашид Ад-Дин бээр мөн тус зохиолын 2-р ботид Жочийн тухай хэсэгт бас бичсэн байдаг. Тэгэхээр Рашид Ад-Дин Бөртэ Мэргидэд баригдахдаа, хөл хүнд байсан гэж сонссон байх нь. Тэгэхдээ энэ бол дам яриа бус, учир нь уг номыг бичихдээ “... ард түмний хүндтэй хүмүүс, бүх эрдэмтэнтэй асуулга лавлагаа явуулж, мөн эртний номуудын агуулгаас (зохих) түүвэр хийж...”<sup>9</sup> ихэд нямбай бичихийг хичээсэн.

Ата Малик Жувэйни ч бүтээлдээ, Жочи Чингисийн ахмад хүү гэдгийг удаа дараа дурджээ. Тэрбээр жишээлбэл, “Чингисийн хүүхдүүдийн тухай” гэдэг бүлэгт Чингис хаан дөрвөн хүүхэдтэй байсан тухай дурдаад, ууган хүү Жочид монголчуудын

<sup>4</sup> “Монголын Нууц Товчоон”, Шинээр хөрвүүлэн буулгаж, тайлбар хийсэн Ш.Чоймаа, Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал I боть, УБ., 2006.55-р тал.

<sup>5</sup> Мөн номын 50-р тал.

<sup>6</sup> Б. Сумьяабаатар, Монголын нууц товчоо, Үсгийн галиг. УБ., 1990, 145-р тал.

<sup>7</sup> J. de Rachewiltz, Index To The Secret History of the Mongols, Indiana University, Bloomington., 1972, p.41.

<sup>8</sup> Рашил Ад Дин. Судрын чуулган, 1-р боть, УБ., 2002, 220-221 дэх тал.

<sup>9</sup> Мөн номын 17-р тал.

хүндэтгэлтэйгээр эрхэлдэг спорт болох ан авын ажлыг даалгасан байна хэмээсэн байна. "To Tushi, the eldest, he assigned hunting and the chase, which is great sport with the Mongols and held in high esteem by them..."<sup>10</sup>

Бөртэ Мэргидэд баригдахдаа хөл хүнд байсан эсэх талаар Сайшаал гуайн бичсэнийг үзье. Тэрбээр "Бөртэ үжин баригдах үедээ бие хүнд байгаад, чөлөөлөгдөх үедээ төрлөө гэж үзэх нь зүйтэй юм. "Д'Оссоны түүх"-д «Жочи гучаад насандаа нас баржээ... Түүний эх Бөртэ үжин анх жирэмслээд байхад Мэргид нар Тэмүжин гэртээ байсангүйг далимдуулан Бөртэг булаан явсан билээ. Ван хан Мэргид вангаас авч, (Тэмүжинд) буцаан өгчээ. Замдаа нэгэн хөвүүн төрснийг Жочи гэв. "Жочи" гэдэг нь монгол үгийн "зочин" гэдэгтэй адил юм.» гэжээ. Энэ нь хэдийгээр "МНТ"-той баахан зөрөөтэй боловч, Бөртэ үжин баригдах үедээ бие хүндтэй байсныг гэрчилж байна"<sup>11</sup> гэжээ.

Бусад зүйлийн тухай үл өгүүлэн хөндсөн сэдвээ хөөн үзвэл Рашид Ад Диний Бөртэ мэргидэд олзлогдохдоо хөл хүнд байсан гэсэн мэдээлэл, (Үүнтэй Оссоны түүх-д байгаа мэдээлэл, Сайшаалт гуайн санал тохирч байна.) Тэмүжиний хэлсэн үгэн дэх эм хөвүүгээ булаалгасан тухай яриа хоёр авцалдаж байгаа юм. Тэгвэл үүнийг дам ч гэсэн батлах өөр зүйл "Монголын нууц товчоо"-нд байна уу? Байнаа, юу гэвэл:

**Нэгэн зүйл.** Чингис Жочийг хөвүүдийн минь ах гэж дөрвөн удаа хэлсэн нь уг номонд бичээстэй байна.

1. Хишиг хуваасан тухай 210 дугаар зүйлд, "Хөвүүдийн минь ах Жочи буй зэ. Гунан Гэнигэсээн тэргүүлж, Жочийн дор түмний ноён болтугай хэмээн зарлиг болов"
2. 239 дүгээр зүйлд, Жочи ойн иргэдийг дагуулж ирсэнийг сайшаан Чингис хэлсэн нь "Хөвүүдийн минь ах, чи гэртээс сая гарч, мөр сайт, одсон газраа эр агтыг үл шархлуулан, үл зовоон, өлзийт ойн иргэнийг оруулж ирэв зэ, чи. Иргэнийг чамд өгсү хэмээн зарлиг болов".
3. 242-р зүйлд, "Чингис хаан зарлиг болж "Эхэд, хөвүүдэд, дүү нарт иргэн хувааж өгье" хэмээн өгөхдөө: "Улс хураан зовсон эх буюу зэ. Хөвүүдийн минь ах Жочи буй зэ. Дүү нарын минь нялх Отчигин буй зэ" гээд Жочид бусад хөвүүдэд өгснөөс хамгийн олон буюу есөн мянган иргэн өгсөн аж.
4. Дөрөв дэх нь 254-р зүйлд, залгамжлагчаа тодруулахад хэлсэн үгийг дээр дурдсан.

Эдгээрийг ажиглахад нэг дэх тохиолдолд Жочи ууган хүү нь учраас түмний ноён түүний дор байх учиртай гэсэн санаа, хоёр дахь тохиолдолд ууган хүү нь өсч тусад орж байгаад баярласан байдал ажиглагдаж байна. Харин гурав дахь тохиолдолд өөрийн ойр дотнынхоноос мах цусны холбоогоороо онцлог хүмүүсийг нэр цохсон байна. Үүнд аргагүй эх, ууган хүү, отгон дүү нь оржээ. Эдгээрийн, Чингис хаантай холбогдох мах цусны холбоо нь онцлог, маргашгүй байсан гэмээр. Дөрөвдэх тохиолдолд залгамжлагчаа тодруулах асуудлыг Чингис хаан бодолгүй байж байгаад, Есүй хатныг хэлэхээр л санасан хэрэг огт биш байх. Тэрбээр хөвүүдээ ажиглан харж, хэн

<sup>10</sup> Genghis Khan. The History of the World-Conqueror by Ata-Malic Juvaini. Translated and edited by J.A. Boyle. Manchester University Press. 1997, p.40.

<sup>11</sup> Сайшаал. Чингис хааны товчоон. Дээд дэвтэр. Уб., 2004, 171-172-р тал

залгамжлагч болох чадвартайг дотроо мэдэж байсан байх. Харин хэлэх цаг болоход нь ёс төрөө бодож эхлээд ууган хүүгээсээ асуусан хэрэг юм.

**Нэгэн зүйл.** Есүй залгамжлагчаа тодруулахыг хүсэж хэлсэн үгэндээ:

“... Тул мэт бие чинь

Тулбас одвоос

Туял мэт улсаа

Хэнд хэмээмү?

**Төрсөн** (А.Ц. онцлов) дөрвөн хүлэг хөвүүдийнхээ хэнийг инү хэмээмүй?”<sup>12</sup> гэжээ. Эн дөрвөн хүүхэд бүгдээрээ өөрийн нь төрсөн хүүхэд гэсэн санаа биш гэж үү? Хэрвээ дөрвөн хүүхдийн нэг нь төрсөн хүүхэд нь биш байсан бол Есүй заавал “төрсөн” гэж хэлэхгүй байсан болов уу.

**Нэгэн зүйл.** Үйл явдал өрнөсөн цаг хугацааг бодож үзвэл Тэмүжин Бөртэ-г авчраад Мэргидэд булаалгах хүртэл нэлээдгүй хугацаа өнгөрчээ. Тэмүжин эм хөвүүгээ булаалгалаа, аварч өгнө үү гэж ирэхэд, Тоорил хан хэлсэн нь: “Би **ноднин** (А.Ц. онцлов) чамд өгүүллээ бус уу? Булган дах над авч ирэхдээ, эцгийн цагийн анд хэмээлдсэн эцэг мэт буюу хэмээн өмсүүлбээс, тэнд би өгүүллрүүн...”<sup>13</sup> гээд туслахаа амалдаг. Тэгэхээр Тэмүжин Бөртэ хоёр нэг гэрт ороод бүтэн жил биш юмаа гэхэд чамгүй хугацаа өнгөрчээ. Тэгвэл Бөртэ Мэргидүүдэд олзлогдоод Тэмүжинг очиж авах хүртэл өнгөрсөн хугацаа Тэмүжин, Хасар, Бэлгүтэй гурав Бурхан Халдунаас мориор Туулын хар түн хүртэл явах, Туулын Хар түнээс мэдээг Хорхоног Жубурт буй Жамухад хүргэх, Жамухад очсон элч эргэж Туулын хар түнд ирэх, тэгээд цэргээ засаад хөдлөх, Жамух Онон мөрний эхэнд Ван хан Тэмүжин хоёрыг хүлээж гурав хонох, тэндээсээ бүгд хөдлөж Сэлэнгийн наана буй Хилгод хүрч мэргидийг дайрах гэсэн энэ л хугацаа юм. Энэ бол яавч 1-3 сар орчмоос хэтрэхгүй хугацаа гэж таамнахад хилсдэхгүй биз ээ. Тэр цагт орондоо унтах завгүй олзлолдон булаацалдаж байсан болохоор цэрэг хөдөлгөх нь тийм ч их хугацаа шаарддаггүй байсан буй заа. Хоогчин эмгэн Мэргидүүдэд тэргэнд унгас тээж яваа гэж хэлсэнийг бодоход Бөртэ-г Мэргидүүд булаасан цаг нь хонины ноос хяргаж болохоор хөөрсөн зун цаг байжээ. Нууц товчооны 109 дүгээр зүйлд Тоорил, Чингис, Жамух гурав Хилго мөрнийг сал уяж гаталсан тухай бичсэнээс үзвэл Бөртэг буцаан авсан цаг дулаан байжээ. Сайшаал гуай Тэмүжин 1178 онд хуримлаж тэр жилээ Тоорил хаантай уулзаж хар булган дахаа өгсөн гэж тодруулсан ба Бөртэг Мэргидээс буцаан авсан Буур хээрийн байлдаан 1179 оны намрын улирлын дунджаар болсон гэжээ<sup>14</sup>.

**Нэгэн зүйл.** Цагаадайн хэлсэн “Чул олзуур” гэдэг үг ямар ч гэсэн Бөртэ хатныг гомдоохоор муу юмуу эсвэл хилс гүтгэсэн үг байсан бололтой. Тиймээс ч Хөхөчос Цагаадайг эхээ гомдоохоор үг хэллээ гэж зэмлэжээ. Ямар тохиолдолд Бөртэ гомдож болох вэ гэвэл Жочийн тухай хов үгийг хүү нь хэлсэнд гомдож болох юм. Дашрамд хэлэхэд “Чул олзуур” хэмээх энэ хоёр үгийн утгыг хэлний эрдэмтэд яг тогтоогоогүй бөгөөд Дамдинсүрэн гуай өгүүлэн буй үйл явдлын ерөнхий утгаар баримжаалж “Орхидос” гэсэн бололтой. Нууц товчоог хятад үсгээр галиглахдаа дэргэд нь бас хятадаар үг бүрийг орчуулсан ажээ. Гэтэл “чул олзуур” хэмээх хоёр үг нь тийм хятад

<sup>12</sup> "Монголын Нууц Товчоон", Шинээр хөрвүүлэн буулгаж, тайлбар хийсэн Ш.Чоймаа, Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал I боть, УБ., 2006, 201-р тал.

<sup>13</sup> Мөн номын 55-р тал.

<sup>14</sup> Сайшаал. Чингис хааны товчоон. Дээд дэвтэр. УБ., 2004, 139, 149 дэх тал.

орчуулгагүй цөөн үгний хоёр нь аж. Энэ нь эдгээр үг Монголын нууц товчооны анхны эхээс хятад үсгээр түүнийг галигласан хүмүүст үл мэдэгдэх утгатай байснаас болсон хэрэг гэлтэй. Одоо ч судлаачдын зарим нь энэ хоёр үг нэг үг байсныг хятад маягаар галиглахад тасалж бичсэн гэх юмуу эсвэл хоёр тусдаа үг гэх мэт янз бүрийн санал гаргадаг байна. Сайшаал гуай “Асуудал бол энэ “чул улжагур” гэсэн үгэнд байна. Энэ үгийг “Нууц товчоон”-ы хятад галиглалд: “chu-l(e)-wu-l(e) cha-wu-ra” гэж хажуугийн орчуулгагүйгээр тэмдэглэж байна. Энэ үгийг Элдэндэй, Оюундалай нарын <<“Монголын Нууц товчоон”-ы харгуулан хянасан дэвтэр>> (737 нүүр)-т “chu-l(e)-wu-l(e)”, “cha-wu-ra” гэж салган залруулжээ. Тиймээс “чул улжагур” биш, харин “цөлүүл зуур” гэдэг үг болжээ. Ц. Дамдинсүрэнгийн өдгөөчилсөн “Нууц товчоон”-д: “Энэ мэргидийн орхидост бид захирагдах гэж үү?” гэжээ. Миний үзэхээр энэ бадаг үг нь “Энэ Мэргидийн цөлүүл зуураар хэрхэн мэдүүлэх (захируулах) буй бид” гэсэн утгатай мэт. “Цөлүүл зуур” гэсэн нь зуурд нь цөлж орхисон гэсэн санааг хариулж байна.”<sup>15</sup>

Тэгэхээр энэ хоёр үг “орхидос” гэсэн утгатай эсэхэд судлаачид эргэлздэг байна. Мэргидэд олзлогдож явсан дорой буурай гэсэн утгаар хэлсэн ч байж болох юм. Гэвч эдгээр үгийн утгыг яг тогтоогоогүй цагт энэ бүхэн нь таамаг, оньсого хэвээр үлдэнэ. Энэ үг орхидос гэсэн утгатай байсан ч бусад баримтууд Жочи “орхидос” биш гэдгийг батлаж байгаа бус уу? “Чул олзуур” гэдэг чинь Цагаадайн л үг шүү дээ.

**Нэгэн зүйл.** Мэргидийг ялсны дараа Бэлгүдэй эхийгээ хайсан тухай авч үзье. “Бэлгүдэйн эх тэнд буй хэмээн заалгаж, Бэлгүдэй эх юүгээн авахаар одож, гэрт инү, Бэлгүдэй баруун үүдээр орохуй лугаа эх инү навтархай нэхий дээлтэй зүүн үүдээр гараад, гадна буй хүмүүнээ өгүүлрүүн: “Хөвүүд минь хаад болжухуй хэмээгдмүй. Би энд муу хүнд учирч, эдүгээ хөвүүдийнхээ нүүр хэр үзэх, би” хэмээгээд гүйж, ой шугуйд шургажухуй. Төдий эрж эс олдлоо” Бэлгүдэйн эхийн үйлдэл одоогийн бидэнд ч ойлгомжтой. Тэгвэл түүнтэй цуг олзлогдсон Бөртэ яасан билээ? “МНТ”-г үзье.

“Тэмүжин дүрвэж айсахун иргэнд “Бөртэ! Бөртэ! хэмээн дуудаж явахуйд учирчухуй. Бөртэ үжин тэд дүрвэхүн иргэнд байжухуй. Тэмүжиний дууг сонсож таньж, тэргэнээс буугаад гүйж ирж, Бөртэ үжин, Хоогчин хоёр Тэмүжиний жолоо цулбуурыг нь шөнө таньж барьжухуй. Саруул бүлгээ. Үзвээс Бөртэ үжинийг таньж, тэврэлдэн тусалцав.”<sup>16</sup> Бөртэгийн үйлдэл Бэлгүдэйн эхийнхээс огт өөр байсан аж. Зугтаж алга болох нь бүү хэл хаана байгааг нь Тэмүжин мэдэхгүй дуудаж явахад, урьдаж таниад гүйж иржээ. Зүгээр ч үгүй тэврэлдэн золгосон байна. Энэ хоёр бүсгүй яагаад ийм өөр өөр байдалтай байв аа? Бэлгүдэйн эх Бөртэгээс насаар эгч байсан нь ойлгомжтой. Нөгөө талаар нөхөр аль эрт бие барсан байлаа. Харин Бөртэ хар багаас сүй тавьсан, ханилж суугаад жил л болж байгаа нөхөртэй залуу бүсгүй. Энэ бүхнээс үзвэл Бөртэд Мэргидэд олзлогдоод байх үед нь ичмээр юм тохиолдсонгүй. Яагаад гэвэл тэр хөл хүнд болоод нэлээд удсан байсан хэрэг. Тийм ч учраас Мэргидүүд Бөртэ-г Чилгэр бөхөд эхнэр юмуу эсвэл татвар эм болгож өгсөнгүй, харин “асруулсан” ажээ. Чилгэр бөхөд өөрт нь Бөртэ-г эхнэр болгох алсын санаа байсан нь түүний зугтаж гараад хэлсэн үгнээс илт. Чилгэр бөх тэр үеийн нийгмийн байдлаараа Бэлгүдэйн эхийн учирсан “муу” хүнтэй ижилхэн байсан болохоор, хэрвээ Бөртэ түүнтэй “учирсан” бол ичвэл ичихээр л байсан хэрэг. Чилгэр бөх зугтаж гараад хэлсэн үгэндээ өөрийгөө :

<sup>15</sup> Мөн номын 171 дэх тал.

<sup>16</sup> “Монголын Нууц Товчоон”, Шинээр хөрвүүлэн буулгаж, тайлбар хийсэн Ш.Чоймаа, Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал I боть, УБ., 2006,61-р тал.

... “Харц муу Чилгэр

Хар толгойдоо бүрэх болов.” гэжээ. “Харц” гэдэг үг тэр үед ч угсаа, язгуургүй, эгэл нэгэн, албат гэсэн утгатай байсныг Жамухын хэлсэн үгнээс мэдэж болно. Тэр хамт явсан нөхөддөө баригдан Чингист хүргэгдэж ирээд хэлсэн нь:

“Хаан андад өгүүл.

Хар хэрээ

Харамбай нугас барих болов.

Харц боол

Хаан эзэндээ гар хүрэх болов.”

Мэргидүүд довтлон айсууг мэдээд зугтах үед Бөртэд морь дутдаг. Нэг моринд дайтах, амь гарахад зайлшгүй хэрэгтэй зүйлээ ачихаас өөр аргагүй байсан байх. Харин Бөртэ-г яагаад ачаатай морийг унуулах, сундалдах, дүүрэх зэрэг боломжуудыг ашиглаагүй, нэг бол тусад нь морь унуулалгүй, тэргэнд суулгах хэрэгтэй болов гэвэл бас л “хөл хүндтэй” байснаас болсон байж болох юм. Өэлүн эх Тэмүлэнийг дүүрч зугтсан байдаг шүү дээ.

Бэлгүдэйн эхийн ой руу зугтсаныг анхаарч тайлбарлах гэсэн оролдлого бас байдгийг эрхбиш анзаарч, өөрийн саналыг хэлэх нь зүйтэй биз ээ. АНУ-ын Жек Ведерфорд гэгч номондоо доктор Х. Лхагвасүрэнтэй ярилцсан байдлаар уг асуудлыг хөндсөн байна. Түүний гол санаа бол Бэлгүдэйн эх, хүү Бэгтэрийг нь алсны төлөө Тэмүжинд хонзон санаж явдаг байж. Тэгээд магадгүй Тэмүжин эхнэрээ авчирлаа гэдгийг Мэргидүүдэд мэдээлсэн байж болох аж. Ийнхүү тэр гэр бүлээсээ урвасан учир ой руу зугтсан юм байх. Ийм таамаглал хийх үндэслэл нь “Мэргэд тэдэнд халдаж ирэх үед Өэлүн хүүхдүүдтэйгээ уул руу, Бөртэ, эмгэн хоёр үхэр тэргээр эсрэг зүгт зугтахад, арван хоёр хүнээс ганцхан Бэлгүдэйн ээж хаашаа ч зугтаалгүй, Мэргэдийг хүлээж суудаг”<sup>17</sup> гэсэн дүгнэлт юм байна.

Тэгвэл тэр үед Бэлгүдэйн эх Тэмүжин нартай хамт байсан уу, үнэхээр Мэргидүүдийг хүлээгээд сууж байсан уу гэдэг асуулт гарна. Монгол хүний ухаанаар бодож үзэх юм бол нэг хүний их, бага хоёр эхнэр өөр өөр гэрт байсан байж таарна. Хаана байсан бэ гэдгийг тодруулахад, Хоогчин эмгэний хэлсэн үг түлхүүр болж байна. Тэрбээр “Юун хүмүүн чи” гэж Мэргидийн цэргүүдийг асуухад “Би Тэмүжинийх буй. Их гэрт хонь хяргахаар ирлээ. Гэртээн харьж айсуй” хэмээв. Тэндээс өгүүллрүүн: “Тэмүжин гэрт буюу юу? Гэр хаана буюу?” хэмээв. Хоогчин эмгэн өгүүллрүүн: Гэр ч ойр буюу. Тэмүжиний үгүй бүхүйг, эс ухав. Хойноос босоод ирэв би хэмээв.”<sup>18</sup>

Тэгэхээр тэр үед, Тэмүжинийхэн хоёр гэртэй байсан ба урд гэрт Тэмүжин байгаа эсэхийг хойт гэрт байгаа хүмүүс мэдэхээргүйгээр тэдгээр гэрүүд зайтай байжээ. Бэлгүдэйн эх хойт гэрт байсан хэрэг. Хоогчин эмгэний үгнээс үзвэл хойт гэр нь “их гэр” байсан ба тэнд мал сүрэг, аж ахуй нь байжээ. Тэнд Бэлгүдэйн эх байж, аж ахуйн талын үүрэг хүлээж байсан ч байж мэдэх юм. Хоогчин эмгэн тэнд хонь хяргахаар очоод одоо буцаж гэр рүүгээ харьж явна гэжээ. Хоогчин эмгэний гэр нь “урд гэр” юм. Учир нь “МНТ”-ны 98-р зүйлд “...Өгээлүн эхийн гэрт хөдлөх Хоогчин эмгэн...” гэж бичжээ. Үүнийг Дамдинсүрэн гуай “Өэлүн эхийн гэрт зарцлагдах” гэж өдгөөчилсөн. Хоогчин “хойноос босоод ирэв, би” гэжээ. Мэргидүүд хойт гэр гэж байгааг Хоогчин эмгэнээс мэдэж, тэнд очоод, Бэлгүдэйн эх байсныг олзолсон хэрэг юм. Тийм болохоор бидний

<sup>17</sup> Жек Ведерфорд. Өнөөгийн уртөнцийг үндэслэгч эзэн Чингис хаан. УБ., 2003, 35-р тал.

<sup>18</sup> “Монголын Нууц Товчоон”, Шинээр хөрвүүлэн буулгаж, тайлбар хийсэн Ш.Чоймаа, Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал I боть, УБ., 2006, 49-р тал.

бодоход Бэлгүйдэйн эх өөрийн нь хэлснээр “муу хүмүүнд” учирсанаас ичсэн хэрэг болой.

Дүгнэн хэлбэл Жочи яах аргагүй Чингисийн төрүүлсэн үр, ууган хүү нь мөн ажээ. Ийнхүү “Монголын нууц товчоо”-г анхааралтай уншвал Жочи Мэргидийн хүүхэд хэмээх таамаг үндэслэл муутай болох нь ажиглагдаж байна.

Дашрамд тэмдэглэхэд “Монголын нууц товчоо” хэмээх манай үндэсний баялаг гэж бүрэн дүүрэн хэлж болох энэхүү гайхамшигт хөлгөн судар нь судалж дуусашгүй баялаг агуулгатай юм. Түүнээс тэр үеийн ёс заншил, соёл, ахуй амьдрал, хувцас хэрэглэл гэх мэт маш олон зүйлийг судалж мэдэж болно. Нэгэн жишээ авахад тэр үеийн монголчууд арьс нэхийнээс өөр юм өмсдөггүй “хөдсөн” байсан гэх яриа байдаг. Тэгвэл “Монголын нууц товчоо”-нд Ван ханы алтан тэрэм, Тогтогагийн болон Дайр усуны алтан бүс, татаарын нутгаас олсон хөвүүний алтан ээмэг, дөрөвчит булгаар доторлосон таж торгон элгэвч, Мэгүжин сүүлтийн мөнгөн өлгий, танат хөнжил гэх мэт тансаг хувцас, хэрэглэл дурдагдсан байдаг.

Нууц товчоо судлалыг цаашид эрчимтэй үргэлжлүүлбээс олон нууцыг тайлах нь магад. Түүний нэг нь эл өгүүлэлд хөндсөн Жочи Чингисийн төрсөн үр мөн болох тухай сэдэв юм.

## SUMMARY

In this article, the author tried to prove that Jochi was the son of Chinggis Khan analyzing from the literary and historical monuments of Mongols. Many secret locks of the Secret History of Mongols could be opened if the research continues vigorously in the future.